



Цагаан Лянхуа Цэцэгийн Судар- Элбэт

Ордоны тухай үлгэрлэл, 7-р бүлэг**The World of the Lotus Sutra**

“Эрт дээр үед Бүхнийг Даван Нэвтэрдэг Агуу Их Оюун Ухаант Будда байжээ. Тэр Будда нь удаан хугацааны туршид бясалгал хийсний эцэст гэгээрэлд хүржээ. Түүнд 16 хүү байв. Буддаг гэгээрэлд хүрснийг мэдээд 16 хүүг Хүлэгийн Эзэн Ариун Хутагт өвөө нь гэрийн зарц нарын хамт түүнтэй уулзахаар явжээ. Бүгд Буддад хүндэтгэлээ илэрхийлсэний дараа “ард түмний төлөө сургаал айлдаж өгнө үү” гэж гуйжээ.

Будда уг гуйлтыг сонсоод тэд нарт Хутагтын Дөрвөн Үнэн болон Арван Хоёр Учир шалтгаан ба Холбооны сургаалыг тайлбарлаж олон хүнийг зовлонгоос нь чөлөөлж чаджээ. Үүнийг өөрийн нүдээр харсан 16 хаан хүү лам болж Буддагийн гэгээрэлд хүрэхийн тулд сургаалыг улам их сурахыг хүсчээ. Тиймээс Будда тэд нарт Цагаан Лянхуа Цэцэгийн Судар гэдэг гайхамшигтай сургаалыг зааж өгчээ. Сургаалаа удаан хугацаа айлдсаны дараа тэрээр гүн бясалгалд орсон юм. Үүнийг харсан 16 лам хүү нар сургаалыг үргэжлүүлэн өөрсдөө айлджээ. Тэд нарын сургаалыг сонссон олон хүн мөн гэгээрлийн замд орохыг хүсчээ.

Түүнээс хойш олон сар, жил өнгөрч бясалгаласаа гарсан Бүхнийг Даван Нэвтэрдэг Агуу Их Оюун Ухаант Будда дуугай босон ингэж хэлэв: “Эдгээр 16 бодисадва нар сургаалыг сайвтар ойлгож, надаас гадна олон будда нарын төлөө мөргөл хийж буян үйлдсэн билээ. Та бүгд эдгээр бодисадва нарын сургаалыг дагаж үйлдэж байвал Буддагийн гэгээрэлд хүрэх болно”.

Шагжамүни үргэжлүүлэн ингэж хэлжээ: “Тэдгээр бодисадва нарын сургаалыг

шүтэн дагасан олон ард дараагаар хэд дахин төрж хувирсан ч ямагт бодисадва нарын дэргэд эргэн очиж сургаалыг нь сонсож байсан ба энэ нь одоо ч үргэжилсэн хэвээр байгаа”.

Шагжамүни мөн уг 16 бодисадва нар нь эцэст нь Будда болж энд тэнд сургаалаа айлдаж байгаа гэдгийг хэлээд 16 дахь бодисадва нь өөрийнх нь төрөл байсныг ч хэлжээ. Тиймээс тэнд цугларан ирсэн бүх шавь лам нар, мөн ирээдүйн бүх шавь лам нар нь бүгд өөрийнх нь шавь байсан юм гэдгийг тайлбарлажээ.

Мөн “энэ ертөнцөд Язгуурын Гэгээрэлд хүрэх арга зам бол нэг л бий. Тэр бол Цагаан Лянхуа Цэцэгийн Сударын сургаал мөн. Гэвч будда нарын хэрэглэх уран арга нь тус тусын ард түмний зан чанараас шалтгаалж янз янз байдаг. Жишээлбэл, таван эрхтэнийхээ шуналд автагдаж өөрөө өөрийгөө зовоож буй хүнд эхлээд тээнэгэлзэх сэтгэлийг нь засан зайлуулж амар тайван болох арга замыг нь зааж өгөх хэрэгтэй байдаг. Энэ нь тухайн хүний нөхцөл байдалд таарсан сургаал учраас үүнийг сонссон хүн шууд итгэж чадна. Үүний тухай “Элбэт Ордоны тухай үлгэрлэл” гэсэн яриагаар дамжуулжээ:

(To be continued)



СЭТГЭЛЭЭ ТЭЖЭЭН ХӨГЖҮҮЛЭХ НЬ

РКК-ийн Ерөнхийлөгч
Нивано Ничико

“Өөрөөсөө эхэлж шүтлэгтэй болох” -ыг зорьсон 20 жил

Би нийгэмлэгийн ерөнхийлөгч болоод энэ 11 сард 20 жил болох гэж байна. Нэг мэдэхэд л он жил урсан өнгөрч энэхүү хугацаанд би гишүүдтэйгээ хамт ямар замаар яаж явахыг нилээд бодон эргэцүүлэн ирсэн. Үүсгэн Байгуулагч бол хүмүүсийг араасаа дагуулж явах хүч чадалтай бас тийм авъяастай ч хүн байсан билээ. Харин би бол эсрэг зантай хүн юм. Тиймээс ч сургаалаас ямар нэгэн тусалцаа олдох болов уу гээд дахин дахин уншиж үзтэл Шагжамүнигийн өөд болох өмнөх яриа нүдэнд туссан юм. Түүнийг өөд болох гэж байгааг мэдсэн шавь нар нь ихэд гаслан гашуудахад тэрээр: “Өөрөө өөрийгөө гэрэлтүүлж, сургаалынхаа замаа гэрэлтүүлэн яв” гэж хэлж захидаг байна.

Үүнийг уншаад би “заавал Үүсгэн Байгуулагч шиг асар их хүчтэй болох шаардлагагүй. Хүн бүрт байдаг өөрийн гэсэн хүч чадлаараа урагшаа тэмүүлж явах нь чухал юм байна” гэж ойлгосон юм. Энэхүү бодлын арга зам нь Буддагийн хүсэж байдаг “бүх хүмүүсийн аврал” гэсэн зорилгонд таарах болов уу гэж бодон нийгэмлэгийнхээ 60 жилийн ойд буюу 1998 онд “хүн бүрийн сэтгэлийг тэжээн хөгжүүлцгээе” гэсэн уриалга гаргасан билээ.



Зэрлэг өвс ч тэжээл болдог

Хүний үндсэн мөн чанарт ямар ч зовлон бэрхшээлийг даван туулж чадах хүч байдаг. Үүнийг биеэр туулж амсаж, бие сэтгэлийн авралыг олох нь буддын шашин юм. Хэн нэгэн нь аварч өгөх биш өөрөө л бүх асуудлыг шийдэж чадах чадвартай байдаг. Тэгвэл бид хэрхэн яаж аврагддаг вэ?

Үүнийг хийсвэр ойлголтоор илэрхийлбэл, "сэтгэлээ тэжээн хөгжүүлэх" явдалд оршдог байна.

Тариагаа тарьж, түүнийхээ ид шимийг авахын тулд юуны өмнө талбайныхаа газраа сайвтар бэлдэж тэжээлтэй болгох хэрэгтэй байдаг. Газар шороо нь зөөлөн, ус тэжээлтэй байж л сайн ургац гарна. Хүн бид ч мөн адил юм. Япон хэлний ханзаар илэрхийлдэг хүний "сэтгэлийн талбай" гэдэг үгийн утгыг задлан тайлбарлавал "хүний үндсэн сэтгэл, чин сэтгэл" буюу "бодисадвагийн үйлийн сэтгэл" гэсэн утгатай билээ. Хүн өөрийнхөө сэтгэлийн талбайг сайвтар хагалж тэжээвэл үзэл бодол нь зөөлөрч, аливаа асуудалд зөв хандаж "энэхүү зүйлээс би юу олж суралцаж чадах вэ" гэж бодох чадвартай болдог байна.

Сэтгэл зөөлрөнө гэдэг нь юуны өмнө амьсгаагаа гүн авч чаддаг болно гэсэн үг билээ. Амьсгалж авч чадсан бүхий зүйлс нь тэжээл болж

хувирана. Үүний ачаар зовлон бэрхшээл гэж бодож байсан зүйлс ч үнэндээ маш чухал зүйл байсан гэдгийг ойлгоно.

Ийнхүү хүн ямагт өөрийнхөө сэтгэлээ тэжээн баяжуулж хөгжүүлэх хэрэгтэй. Амжилтанд хүрэхийн тулд хамгийн гол нь их зантай болж болохгүй юм.

Их зан гаргах, онгирохьхувиа хичээх гэсэн зангаа хаяж, төлөв даруу амьдрахын тулд бие сэтгэлээ болон үгээ барьж хянан аливаа үед уян зөөлөн сэтгэлээр хандаж байх нь чухал юм.

Гэвч хүний шунал, уур, мунхаг гэсэн зэрлэг өвс мэт зангууд хичнээн авч хаясан ч эргээд ургаад гараад ирдэг увдистай зүйл билээ. Тэдгээрийг зэрлэг өвстэй адил нэг нэгээр нь зулгааж хаяна гэдэг бол асар их хөдөлмөр энерги шаардсан асуудал болно. Тийм учраас тэдгээрийг ч мөн сэтгэлийнхээ талбайн нэгэн тэжээл болгож сэтгэлээ хөгжүүлэх нь буддын сургаалын зам болно.

Би дээр үед Сүганүмад байхдаа тариалангийн талбайн зэрлэг өвсийг зулгааж авдаг байлаа. Зулгааж авсан зэрлэг өвсөө шороон дотор холиод ургацын тэжээл болгодог байв.

Бид ч мөн сэтгэлийнхээ зэрлэг өвсөө тэжээл болгож, шинэ эрч хүчээр сольж түүнийгээ бусдын төлөө зарцуулан явбал буддын сургаалын заманд орох болно.

“Косэй” 2011 оны 11 сарын дугаараас



Инээмсэглэл бол тэнгэрийн цэцэг

РКК-ын дараах үеийн ерөнхийлөгч Нивано Коошо багш

Үүсгэн Байгуулагч ба түүний бяцхан үрс

Жаахан хүүхэд бүр залуухан ах,эгч нарт тун дуртай байдаг.Олон хүний дундаас хамгийн залуугийг нь олж аваад очдог.Манай хүүхдүүд ч мөн адил боловч нэг л удаа өөр байсан билээ.Тэр бол Үүсгэн Байгуулагч юм.

Том охин маань төрөхөд Үүсгэн Байгуулагч “анхны зээнцэр”гээд ихэд баярлаж байлаа.Үүсгэн Байгуулагч,зээнцэр хоёрын насны ялгаа нь 90 нас байсан боловч охин маань Үүсгэн Байгуулагчид маш хайртай байсан.

Хүүхдээ төрүүлэхийн тулд би аав,ээж дээрээ ирсэн байсан бөгөөд охиноо 5 сартай болмогц эргээд Ромд байсан нөхөр лүүүгээ харьсан билээ.Гадаадад ганцаараа анх удаа хүүхдээ өсгөхөд их л хэцүү байв.Ялангуяа охин маань хоолонд тун дургүй байсан тул зовлонтой санагдаж байлаа.

Жилийн дараа ой хагастай охиноо дагуулаад нутагтаа буцаж иртэл ойр хавийн хүмүүс бүгд л “ямар туранхай эцэнхий вэ”,”ээж,аав нь олигтой хооллохгүй л учраас ийм байгаа”гэх мэтээр зэмлэж их л эвгүй байлаа.

Тэр үед Үүсгэн Байгуулагч маань нас ахисны улмаас ихэд турсан байсан тул эмч түүнд хоолоо нэмж идэхийг зөвлөсөн билээ.Тиймээс ч Үүсгэн Байгуулагч маань охинд минь.”Өвөө нь бас идэх учраас хоёюулаа хичээе”гэж хэлдэг байв.Үүсгэн Байгуулагч “Хөөрхөн ханьтай боллоо”гээд тэр өдрөөс хойш охины хажууд сууж иддэг болов.Эргээд Ром уруу буцаад охин маань хоол идэхгүй үед өвөөгөөс нь ирсэн видео бичлэгийг үзүүлэхэд хоол идэж буй өвөөгийнхөө дүрсийг хараад охин маань баяртайгаар хоолоо иддэг байв.

Дараа жил нь хоёр ойлд хүрсэн охиноо дагуулаад гэртээ ирэхэд охин маань оройн хоол дуусмагц шууд Үүсгэн Байгуулагчийг дагаад л хаа явсан ч араас нь дагадаг байв.Өвөөдөө үнэхээр хайртай гэдэг нь мэдэгдэж байв.

Нивано Коошо

Нивано Ничико ерөнхийлөгчийн том охин болж Токиод мэндэлсэн. Хуулч мэргэжлээр их сургуулиа дүүргэсний дараагаар РКК-ын удирдах албаны мэргэжилтэн бэлтгэх “Такурин” сургуулийн үндсэн ангид элсэн суралцаж төгссөн.

Өдгөө Цагаан Лянхуа Сударыг судлангаа Косей Кайгийн гишүүд болон сүсэгтэн олонд ном айлдаж, гадна дотны шашинтнуудын хамтын ажиллагаан дээр анхааран ажиллаж байна. Түүнчлэн дараа үеийн ерөнхийлөгчөөр сонгогдох дияаны үйлээ үргэлжлүүлсээр байгаа. Мүнэхиротой гэрлэсэн бөгөөд нэг хүү, гурван охины ээж болсон.



Дараа жил нь гурван нас хүрсэн охиноо төрөөд зургаан сар болж байсан дүүтэй нь хамт дагуулаад басл нутагтаа ирсэн юм. Нисэх буудлаас шууд Үүсгэн Байгуулагчийн хэвтэж байсан Косэй эмнэлэг үрүү явсан юм. Үүсгэн Байгуулагчийг амьд байхад төрсөн хоёр дахь охин маань өвөөтэйгээ ганц ч удаа уулзаж чадалгүй өнгөрвөл үнэхээр харамсалтай санагдаж байсан. Ромоос 15 цаг гаруй нисэж хүүхдүүд маань ядарсандаа болоод унтаж байсан боловч Үүсгэн Байгуулагчийн хэвтэж байсан өрөө үрүү нь тэврээд очсон юм.

Эмч, сувилагч, бичээч, зурагчин гээд баахан хүмүүс цугларан тойрсон байсан. Тэдний дунд том охин маань: “Үүсгэн Байгуулагч аа, би эргээд ирлээ” гэж мэндчилсэн билээ. “Манай гэрийн шинэ хүн” гээд би бага охиноо үзүүлэхэд Үүсгэн Байгуулагч “өө, тийм үү, за гэртээ тавтай морилоорой” гэж хэлэхэд нялх охин маань нойрноосоо сэрж, нүдээ томоор нээгээд гараа сунган барьсан юм. Тэр агшинг ерөөс мартаж чаддаггүй юм.

Түүнээс хойш хоёр сарын дараа 10 сарын 3-нд бид Ром уруу буцахаас өмнөх өдөр нь хүүхдүүдээ дагуулаад Үүсгэн Байгуулагчийг дахин эргэж салах мэндчилгээгээ хийгээд явсан юм. Тэр нь бидний сүүлчийн уулзалт болсон.

Хоорондоо амин холбоотой хүмүүс

Бүх шашны сургаал нь “дайснаа ч гэсэн хайрл”, “бүх зүйлд нигүүлсэхүйн сэтгэлээр ханд” гэж сургадаг билээ. Энэхүү сургаал нь хүнд хичнээн нандин чухал гэдгийг хүн бүр ойлгодог боловч бүх хүмүүс уг сургаалыг биелүүлэн дагадаг байсан бол манай дэлхий аль эртнээс энх тайван ертөнц болох байсан юм.

Дэлхийн Шашны сүсэгтнүүдийн хурал цуглаанд оролцоход “Бурхан бол ганц боловч олон нэртэй” гэсэн үгийг ихээр дуулдаг юм. Бурхан гэж хэлсэн ч Будда гэж хэлсэн ч эцсийн эцэст хэлэхэд “тэнгэр газрын бүхий зүйлсийг бий болгож амилуулж байдаг Агуу Их Амь” юм гэж би боддог.


Мөн жинхэнэ шүтлэг гэдэг нь тэрхүү Агуу Их Амьд амилагдан амьдарч байгаагаа ухаарч, Агуу Их Амийн зүй ёсоор нь амьдрахыг хэлнэ. Тийм учраас мөргөвөл мөнгөтэй болно гэсэн сэтгэлгээ бол шүтлэг биш юм.

Энэ нийгмийн бүх хүмүүс Агуу Их Амийн ачаар амилагдан амьдарч буй амин холбоотой нөхөд гэдгийг чин сэтгэлээсээ хүлээн авбал анх хажууд дахь хүнээ хайрлаж, амьд буй бүхий зүйлд нигүүлсэхүйн сэтгэлээр ханддаг болно. Тэгснээр сургаалыг биелүүлэн үйлдэж эхлэнэ.

Үүсгэн Байгуулагчийн Үг 5 (Kosei Publishing Co.), 196-197х

Рисшо Косей Кайгийн тухай

Рисшо Косей кай нь 1938 онд Нивано Никкё болон Наганума Мёко нарын санаачилгаар үүсэн байгуулагдсан юм. Манай байгууллага нь “Лянхуа цэцгийн гурван судар”-ыг номлолынхоо эх үүсвэр болгож, тэр бүлээрээ шүтэх шашны нэгэн шинэ хэлбэр бөгөөд сургаалийг амьдрал ахуй, нийгэмд хэрэгжүүлж аз жаргалтай амьдрал, гэгээтэй нийгэм, дэлхийн энх тайваныг зорьдог юм.



SHAN-ZAI Volume 74 (November 2011)

[Эрхлэн гаргач] Рисшо Косей Кай Сургаал дэлгэрүүлэх олон улсын төв.

Хаяг: Fumonkan, 2-6-1 Wada Suginami-ku, Tokyo 166-8537 Japan TEL: 03-5341-1124 FAX: 03-5341-1224 E-mail : shanzai@kosei-kai.or.jp

※Энэхүү сэтгүүл нь Япон, Англи, Хятад, Солонгос хэл дээр тогтмол хэвлэгдэн гардаг бөгөөд зарим дугаар нь бусад орны хэл дээр ч хэвлэгдэн гардаг. ※Санал, сэтгэгдэл байвал бидэнтэй холбоо барина уу. ※ Хувийн зорилгоор ашиглах тохиолдолд Олон улсын салбартай холбоо барина уу.